



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 07 сарын 23 өдөр

Дугаар СХМ-2024/05

Сүхбаатар сум

Алтанбулаг сумын Засаг даргын тамгын
Газрын Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн
Хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 02 дугаартай "Санхүүгийн хяналтын ажлын удирдамж"-аар Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2 Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Ахлах дотоод аудитор Т.Мөнхзул, Дотоод аудитор Г.Дорждэрэм нарын бүрэлдэхүүнтэйгээр 2024 оны 07 дүгээр сарын 08-ны өдрөөс ажлын 10 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.3 Шалгалтад Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газрын (цаашид сумын ЗДТГ гэх)-ын 2024 оны эхний хагас жилийн санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4 Алтанбулаг сумын ЗДТГ нь улсын бүртгэлийн 9057439 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100130155001 дугаартай үндсэн данс, 100130155408 дугаартай нэмэлт, Хаан банк дах 5676210253 дугаар жижиг мөнгөн сангийн данстай.

Алтанбулаг сумын Төсвийн орлого зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг сумын ЗДТГ-ын дарга Ү.Янжиндулам, 2-р гарын үсгийг Ерөнхий нягтлан бодогч Э. Цэнд-Аюуш нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж, сумын төсвийн орлого, зарцуулалтыг нэгтгэх, хянах, тайлагнах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж ирсэн байна.

1.5 Алтанбулаг сумын ЗДТГ нь улс төрийн албан тушаалтан 5, төрийн захиргааны албан хаагч 9, төрийн үйлчилгээний бусад албан хаагч 6, гэрээт ажилтан 5 нийт 25 хүний орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна.

4324001108

1.6 Алтанбулаг сумын ТТЗ нь үйл ажиллагаандаа төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх, боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлж, мэргэшсэн тогтвортой, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд анхаарч ажилласан байна

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

2.1.1 Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 86,2 хувь, Сэлэнгэ аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний биелэлт 81.3 хувь, хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 79,2 хувь, Сэлэнгэ аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт 72,3 хувь, зарласан жил “Аялал жуулчлал-ногоон хөгжлийг дэмжих жил”-ийн ажлын төлөвлөгөөг гарган 72,7 хувьтай хэрэгжүүлсэн байна.

2.1.2 Төрийн албаны Зөвлөлөөс төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, чадавхжуулах зорилгоор зохион байгуулдаг “Гүрэв” гарагийн буюу “7:4:10” арга зүйн 13 удаагийн сургалтад сумын төсвийн байгууллагын давхардсан тоогоор 241 албан хаагчид хамрагдсан байна.

2.1.3 Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагааны хэрэгжилтийн хүрээнд 15,318.5 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт бий болгож 4,766.2 мянган төгрөгийг зарцуулж 10,552.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна

2.1.4 Сумын ЗДТГ нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байна.

Төсвийн орлогын төлөвлөлт

Хүснэгт 1.

(мянган төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	2024 оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	608,362.9	499,766.0
1320	Орон нутгийн төсвийн санхүүжилт	608,110.9	499,225.0
120004	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого	252.0	541.0

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогоос 499,225.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 541.0 мянган төгрөг, нийт 499,766.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна

2.1.5 Бэлэн мөнгөний кассын тайланг нягтлан шалгахад нийт 1,000.9 мянган төгрөгийн орлого авч, зарцуулсан байна. Үүнд:

- Сумын Засаг даргын 2024 оны 05 сарын 06-ны өдрийн А/76 дугаар захирамжаар Засаг даргын нэрэмжит спортын 5 төрөлт тэмцээний дагалдах мөнгөн шагналд 450.0 мянган төгрөгийг,
- Сумын Засаг даргын 2024 оны 05 сарын 06-ны өдрийн А/79 дугаар захирамжаар төрийн албан хаагчдын дунд зохион байгуулсан Монгол бичгийн олимпиад зохион байгуулах арга хэмжээний зардалд 274.0 мянган төгрөгийг,
- Хувьсгалчдын баяр наадмын тохижилтын ажлын засварын материал болон буухиа тэмцээн, замын хураамж, хөдөөгийн багийн конторын цонхны хүрээ засварлах хадаас, шүрүүлний үнэ зэрэгт 276.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Нягтлан бодогч, нярав нарт, цаашид жижиг мөнгөн сангийн дансаар дамжуулан зарцуулсан мөнгөн хөрөнгийн тайлан, зарцуулалтыг нотолсон анхан шатны баримтыг бүрэн гүйцэт бүрдүүлсний үндсэн дээр санхүүжилтийг олгож байх зөвлөмж өгч ажиллаа.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2.2.1 Батлагдсан төсөв:

2024 оны эхний хагас жилийн байдлаар 7 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 608,362.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас орон нутгийн төсвөөс 499,766.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Хүснэгт 2.

(мянган төгрөгөөр)

№	Эдийн засгийн ангилал	Нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
1	70106	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	538,450.5	450,961.2
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	369,348.6	306,295.0
1.2	80106	Баг, хорооны ҮАЗардал	52,937.7	44,993.5
1.3	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	25,618.0	25,300.0
1.4	80112	Нийтлэг үйлчилгээ	48,003.8	43,064.3
1.5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	31,694.4	26,391.4
1.6	81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	9,600.0	3,678.0
1.7	83112	Хөтөлбөр төслийн дотоод урсгал	1,248.0	1,239.0
2	70503	Орон нутгийн зорилгот ХОруулал	8,000.0	8,000.0
2.1	80918	Бусад	8,000.0	8,000.0

3	71413	Байгал орчин хамгаалан нөхөн сэргээх	28,112.4	7,446.8
3.1	210801	Бусад нийтлэг АҮТХураамж	28,112.4	7,446.8
4	71502	Хот байгуулалт, тохижилт	1,800.0	1,770.0
4.1	210801	Бусад нийтлэг АҮТХураамж	1,800.0	1,770.0
5	82212	Хур хог хаягдал, орчны бохирдл	30,500.0	30,385.6
5.1	210801	Бусад нийтлэг АҮТХураамж	30,500.0	30,385.6
6	72206	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	1,000.0	702.4
6.1	210801	Бусад нийтлэг АҮТХураамж	1,000.0	702.4
7	72208	Ахмад насны хөгжил хамгаалал	500.0	500.0
7.1	210801	Бусад нийтлэг АҮТХураамж	500.0	500.0
Нийт дүн			608,362.9	499,766.0

Төсвийн орлогын гүйцэтгэл 499,766.0 мянган төгрөг буюу 82.1 хувьтай тайлагнагдсан байна.

2.2.2. 2024 оны үйл ажиллагааны батлагдсан төсөв, гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав:

Хүснэгт 3.

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024 оны эхний хагас жил		хэмнэлт/+/ хэтрэлт /-/	Хувь
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл		
1	Үндсэн цалин	187,098.6	153,305.3	33,793.3	81.9
2	Нэмэгдэл	180,891.6	151,708.8	29,182.8	83.9
4	Урамшуулал	16,321.8	20,318.7	- 3,996.9	124.5
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалын дүн	384,312.0	325,332.8	58,979.2	84.7
6	Ажил олгогчоос төлөх НД-ын шимтгэл	48,074.5	35,977.9	12,096.6	74.8
7	Гэрэл цахилгаан	25,300.0	25,300.0	0.0	100.0
8	Түлш, халаалт	96.0	-	96.0	-
9	Цэвэр, бохир ус	222.0	-	222.0	-
10	Байр ашиглахтай холбоотой нийт зардал	25,618.0	25,300.0	318.0	98.8
14	Бичиг хэрэг	2,892.0	2,339.3	552.8	80.9
15	Тээвэр, шатахуун	8,761.2	8,169.9	591.3	93.3
16	Шуудан, холбоо, интернэт	1,902.0	1,877.2	24.8	98.7
17	Бага үнэтэй түргэн элэгдэх	1,236.0	1,379.6	- 143.6	111.6

18	Хангамж бараа материалын зардлын дүн	14,791.2	13,765.9	1,025.3	93.1
19	Нормын хувцас, зөөлөн эдлэл	615.3	24.4	590.9	4.0
20	Нормативт зардал	615.3	24.4	590.9	4.0
21	Багаж, техник, хэрэгсэл	1,542.0	1,158.7	383.3	75.1
22	Урсгал засвар	3,252.0	3,240.7	11.3	99.7
23	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	432.0	123.9	308.1	28.7
24	Эд хогшилын зардлын дүн	5,226.0	4,523.3	702.8	86.6
25	Дотоод албан томилолт	3,598.0	3,454.0	144.0	96.0
26	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,940.9	50,383.8	21,557.1	70.0
27	Тээврийн хэрэгслийн даатгал татвар оношлогоо	1,527.6	805.1	722.5	52.7
28	Мэдээлэл технологийн үйлчилгээ	550.0	180.0	370.0	32.7
29	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	700.0	700.0	-	100.0
30	БГАУ, бараа үйлчилгээний бусад зардлын дүн	74,718.5	52,068.9	22,649.6	69.7
31	Бараа үйлчилгээний бусад зардал	11,100.0	4,759.4	6,340.6	42.9
32	Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал	615.0	168.0	447.0	27.3
33	Бараа үйлчилгээний бусад зардал	11,715.0	4,927.4	6,787.6	42.1
34	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	392.4	200.0	192.4	51.0
35	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох тэтгэмж	31,302.0	26,191.4	5,110.6	83.7
36	Урсгал шилжүүлэгийн дүн	31,694.4	26,391.4	5,303.0	83.3
37	Бусад хөрөнгө	8,000.0	8,000.0	-	100.0
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		608,362.9	499,766.0	108,596.9	82.1

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 58,979.2 мянган төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зардлыг 12,096.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 318.1 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 1,025.3 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 590.9 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 144.0 мянган төгрөгөөр, эд хогшлын зардлыг 702.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 22,649.6 мянган төгрөгөөр урсгал засварын зардал 5,303.0 мянган төгрөг тус тус хэмнэж, нийт 108,596.9 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

ЗДТГ-ын ажилчдын эрүүл мэндийн үзлэгийн төлбөр 3,820.8 мянган төгрөгийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийн зардлаас бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Нягтлан бодогчид цаашид төсвийн төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн, эдийн засгийн ангиллаар үнэн зөв төлөвлөж байх зөвлөмжийг өгч ажиллаа.

2.2.3 Нэмэлт санхүүжилтийн дансанд: өмнөх оны хэмнэлтээс 5,154.0 мянган төгрөг, Аймгийн ЗДНХ-өөс 85.9 мянган төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс 842.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 9,236.0 мянган төгрөг зэрэг нийт 15,318,5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 2,921.2 мянган төгрөгийн бараа материал, 1,845.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авах зэрэгт нийт 4,766.2 мянган төгрөгийг зарцуулж оны эхний хагас жилийн байдлаар 10,552.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, бий болсон бараа, материалыг бүрэн орлогод бүртгээгүй заримыг шууд зарлагдаж мөнгөн гүйлгээний тайланд тусгасан байна.

Хүснэгт 4.

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,766.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,766.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,766.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,845.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,921.2
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,318.5
33	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон	9,236.0
34	ЗДНөөц хөрөнгөөс	85.9
35	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	842.6
36	Өмнөх оны санхүүжилтийн хэмнэлтээс	5,154.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,552.3

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 9,236.0 мянган төгрөг нэмэлт орлого нь:

- Тендерийн үйл ажиллагааны зардал 560.0 мянган төгрөг,
- Мал бүхий иргэдийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор бэлтгэсэн өвс худалдан борлуулсны орлого 3,861.0 мянган төгрөг,
- Буудай худалдан борлуулсны орлого 3,175.0 мянган төгрөг,
- Халтар арвай 390.0 мянган төгрөг,
- Банз худалдан борлуулсны 1,250.0 мянган төгрөг зэргээс бүрдсэн байна.

2.3. Санхүүгийн үйл ажиллагааны явц, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Үндсэн хөрөнгө: ЗДТГ нь барилга байгууламж 18 ширхэг 551,393.2 мянган төгрөг, авто тээврийн хэрэгсэл 11 ширхэг 235,740.6 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 183 ширхэг 288,835.7 мянган төгрөг, тавилга эд хогшил 489 ширхэг 82,500.2

мянган төгрөг, бусад биет бус хөрөнгө 6 ширхэг 150,879.0 мянган төгрөг, зам гүүрний байгууламж 2,586,140.2 мянган төгрөг, программ хангамж 1,999.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 178,447.5 мянган төгрөгөөр өссөн нь барилга байгууламжийн дансанд 8,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий зөөврийн сууц худалдан авсан мөн 192,847.4 мянган төгрөгийн хүлэмжийн парк болон авто тээврийн хэрэгслийн дансанд 2,600.0 төгрөгийн өртөг бүхий 1ш мотоциклыг тус тус үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авч бүртгэсэн байна.

Пи Си Молл ХХК-аас зурагт 636.7 мянган төгрөг, Сэлэнгэ мэлмий камер ХХК-аас камер 550.0 мянган төгрөг, нийт 1,186.7 мянган төгрөгийн хөрөнгийг орон нутгийн санхүүжилтээр бий болгосон боловч хүлээж авсан баримтгүй, үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна.

Үндсэн хөрөнгийн данснаас 25,000.0 мянган төгрөг бүхий өртөгтэй 2ш автомашиныг акталсан баримттай байна.

Ашиглах боломжгүй 10,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий 5 асар майхан, 5,369.2 мянган төгрөгийн өртөг бүхий спортын болон тоглоомын хэрэгсэл зэрэг хөрөнгүүд санхүүгийн тайланд бүртгэлтэй байна.

Бараа материал: 2024 оны эхэнд 63,135.1 мянган төгрөг, эхний хагас жилийн байдлаар нэмэгдсэн 17,569.2 мянган төгрөг, хасагдсан 14,780.7 мянган төгрөг, үлдэгдэл 65,923.6 мянган төгрөг болж 2,788.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант хугацаанд 3,040.0 мянган төгрөгийн бичиг хэрэг, 3,782.2 мянган төгрөгийн аж ахуйн материал, 10,195.0 мянган төгрөгийн түлш шатахуун, 551.9 мянган төгрөгийн хүнсний материал худалдаж авсан.

Үүнээс 3,279.1 мянган төгрөгийн өртөг бүхий бараа материалыг холбогдох бараа материалын дансанд бүртгэж орлогоор авлаагүй байна.

Албан хэрэгцээнд зориулж 2,815.6 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 1,233.7 мянган төгрөгийн аж ахуйн материал, 10,195.0 мянган төгрөгийн түлш шатахуун, 536.3 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулсан баримттай

Шатахууны зарцуулалтын тайлагналыг санхүүгийн анхан шатны баримтын бүрдэлтэй тулган тооцооллыг дахин хянаж үзэхэд шатахуун зарцуулалтын нормыг мөрдөөгүйгээс 1,795.4 мянган төгрөгийн шатахууныг илүү олгосон бөгөөд шаардах хуудас, зарлагын баримтгүй, бараа материалын тайланд дизель түлш, бензин гэсэн 2 ангиллаар бөөн дүнгээр бүртгэсэн байна.

2024.06.03-ны өдрийн А/14 тушаалаар томилогдсон тооллогын комисс нь эд хөрөнгийн тооллогыг хийж акт үйлдэн баталгаажуулж актлах шаардлагатай элэгдлээ нөхсөн хөрөнгийг данс бүртгэлээс хасуулах тухай дүгнэлтийг сумын ИТХ-ын тогтоолоор баталгаажуулж хүсэлтийн хамт аймгийн орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн байна.

Өмч хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 4.

(мянган төгрөгөөр)

№	Хөрөнгийн хөдлөлийн утга	Орлого зарлагын гүйлгээний утга	Өмч хөрөнгө:	
			Үндсэн хөрөнгө	Бараа материал
1	Оны эхний үлдэгдэл		3,897,488.4	63,135.1
2	Төсвийн эх үүсвэрээр	худалдан авсан	8,000.0	17,569.2
3	Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс	шилжүүлэн авсан	195,447.4	
4	Бусад /дахин үнэлсэн/	шилжүүлэн авсан	0	
5	Бусад		0	
6	Орлогын дүн		203,447.4	17,569.2
7	Үйл ажиллагаанд зарцуулсан	анхан шатны баримт		14,780.7
8	Байгууллагуудад шилжүүлсэн	шилжүүлсэн		
9	Акталж данснаас хассан	тушаалаар	25,000.0	
10	Зарлагын гүйлгээний дүн		25,000.0	14,780.7
	Оны эцсийн үлдэгдэл		4,075,935.8	65,923.6

2.4 Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

2024 онд сумын ИТХ-ын ажлын албанд ажиллагсдын орон тоо, цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн батлагдсан төсөв, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийлээ:

Хүснэгт 5.

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Засаг даргын тамгын газар		Багийн засаг дарга		Гэрээт ажилтан	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
1	Үндсэн цалин	143,808.6	114,539.5	24,750.0	21,026.8	18,540.0	17,738.9
2	Нэмэгдэл цалин	142,281.6	116,687.4	16,650.0	14,682.9	21,960.0	20,338.4
3	Урамшуулал	11,686.8	15,781.1	2,475.0	3,037.6	2,160.0	1,500.1
5	Цалин хөлс нэмэгдэл дүн	297,777.0	247,008.0	43,875.0	38,747.3	42,660.0	39,577.4
5	Ажил олгогчоос төлөх НДШ	37,235.7	28,726.7	5,495.0	3,764.3	5,343.8	3,486.9
	Цалин хөлс НДШ-тэй холбоотой	335,012.7	257,734.7	49,370.0	42,511.6	48,003.8	43,064.3

нийт зардлын дүн						
Орон тооны мэдээлэл	17	17	3	3	5	5

Сумын ЗДТГ нь 25 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж цалин хөлсний нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 432,386.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 343,310.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор хөдөө орон нутагт ажиллаж буй төрийн албан хаагчдад үндсэн цалингийн 40% -аар нэмэгдэл олгох, 2024 оны 84 дүгээр тогтоолоор төрийн захиргааны болон улс төрийн албан хаагчдын үндсэн цалинг 10%-аар, төрийн үйлчилгээний болон гэрээт ажилчдын үндсэн цалинг 20%-аар тус тус нэмэгдүүлснээр байгууллагын ажилчдын цалин дунджаар 2,1 сая төгрөг болсон. Энэ нь өмнөх онтой харьцуулахад албан хаагчдын цалин 50-60%-аар нэмэгдсэн байна.

Ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоолт, олголтын байдлыг хяналт шалгалтын явцад цалингийн дэлгэрэнгүй цэсээс хүн тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, батлагдсан цагийн тооцоо, нэмэгдэл суутгал, тооцох тушаал шийдвэртэй тулган баталгаажуулахын зэрэгцээ НДШ-ийн дэлгэрэнгүй НД8 тайлантай нэг бүрчлэн тулган шалгахад: тохижилт үйлчилгээний гэрээт ажилчдын сар бүрийн ирцийг бүртгэсэн ажилтны гарын үсэггүй, цагийн бүртгэлийг хянаж баталгаажуулаагүй байна.

Цаашид тохижилт үйлчилгээний ажилчдын ажилласан цагийг бүртгэж, сар бүр баталгаажуулж байх, албан хаагчдад цалин хөлс олгох тушаалд бусад холбогдох нэмэгдлүүдийг үнэн зөвөөр оруулж ажиллах талаар дарга, нягтлан бодогч, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд холбогдох зөвлөгөөг өгч ажиллалаа.

2.5 Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Тус сумын ЗДТГ нь 2024 онд төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх томоохон худалдан авалт байхгүй байна.

Сумын ЗДТГ нь 2024 онд төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний 39,195.1 мянган төгрөгийн гэрээг нийт 6 иргэн, аж ахуй нэгж байгууллагатай гэрээг байгуулсан. Гэрээний хэрэгжилтийг дүгнэн актаар, төлбөр тооцооны үлдэгдлийг тооцооны үлдэгдлийн баталгааны маягтаар тус тус баталгаажуулаагүй, үр дүнг тооцоогүй байна.

Нягтлан бодогчид гэрээний хэрэгжилтийг дүгнэн актаар баталгаажуулах, төлбөр тооцооны үлдэгдлийг тооцооны үлдэгдлийн баталгааны маягтаар баталгаажуулж байхыг зөвлөв.

2.6. Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих

Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр иргэн Э.Оюунбаттай 11,500.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий "Татварын хэсэгт зөөврийн байр худалдан авах" гэрээ байгуулсан.

Зөөврийн сууцыг 2024 оны 1 сард бэлтгэн нийлүүлэгчээс хүлээн авч үлдэгдэл 8,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч хүлээн авсан тухай акт үйлдэж хүлээлцээгүй, үндсэн хөрөнгөд 8,000.0 мянган төгрөгөөр бүртгэсэн байна.

"Монголын баялаг 330" төсөл хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 1 дүгээр сард Алтанбулаг сумын түүх соёлын дурсгал болон соёлын өвийн бүртгэл мэдээллийн санг дүрсжүүлэн баримтжуулж архив үүсгэх зорилготой 4,879.6 мянган төгрөгийн өртөг бүхий арга хэмжээг санхүүжүүлэхээр гэрээ байгуулсан.

Уг ажлыг гүйцэтгэж дуусаагүй байхад Монголын баялаг өв соёл ХХК-ын дансанд төлбөрийг 2024 оны 4,5,6 сард хуваан шилжүүлж дуусгасан байна.

Мөн иргэн Ц.Гэрэлт-Одод самбарын үнэ 6,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч данс бүртгэлд орлого аваагүй байршуулаагүй байна.

Цаашид анхан шатны баримтыг зохих журмын дагуу бүрдүүлж, худалдан авсан болон шилжиж ирсэн хөрөнгийг акт үйлдэн хүлээн авч бүртгэл, тайланд тусгаж ажиллахыг зөвлөв.

2.7 Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт үр дүн

Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 9,600.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 3,678.0 мянган төгрөгийн санхүүжилт авч 3 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

2.8 Өмнөх шалгалтын талаар

Хүснэгт 6.

(мянган төгрөгөөр)

№	Зөрчлийн шийдвэрлэлт	Мөнгөн дүн	Товч утга	Хийсэн ажлын биелэлт	
				Тайлбар	Хувь
1	Албан шаардлага	12,500.0	Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 12,500.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий "Татварын хэсэгт зөөврийн байр худалдан авах" төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт 12,760.0 мянган төгрөг зарцуулж, төсөвт өртгийг 260.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн боловч гэрээт хугацаанд уг зөөврийн сууцыг бэлтгэн нийлүүлээгүйгээс 12,760.0 мянган төгрөгийн авлага үүсгэж, бүртгэлд, тайланд урьдчилж гарсан зардлаар тайлагнаагүй	Татварын байрны төлбөрийн 7.470.0 мянган төгрөгийг буцаан төлүүлэхээр Хан-Уул дүүргийн цагдаагийн газрын нэгдүгээр хэлтэст өргөдөл гарган шалгуулж байгаа.	59.8

2	Албан шаардлага	5,150.0	ЖМС-ын дансгүйгээс шалтгаалан ЗДТГ-ын жолооч, жижүүр, багийн Засаг дарга нарын дансанд анхан шатны баримтын бүрдэлгүйгээр шилжүүлсэн	Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ыг мөрдлөг болгон Хаан банк дахь 5676210264 тоот кассын дансаар гүйлгээ дамжуулан бүртгэлд тусгаж анхан шатны баримтыг бүрдүүлэн ажиллаж байна.	100
3	Зөвлөмж	3,939.9	Бараа, ажил үйлчилгээний зардлаас эд, хогшил, урсгал засварын зардал, бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардалд бүлэг хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй	Зардлын бүлэг хооронд зарцуулах журмыг баримтлан ажиллана.	100
4	Зөвлөмж	9,280.0	Анхан шатны баримтын бүрдэл дутуу буюу жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт зэрэг үзүүлэлтүүдийг бүрэн хөтлөлгүйгээр зарцуулсан.	Жолоочийн замын хуудсыг бүрэн бөглөж замын маршрутыг батлуулсны дараа шатахуун олгоно.	70
5	Зөвлөмж	-	Сумын ЗДТГ, ИТХ-ын үйл ажиллагаанд ашиглагдаж буй хуучин тээврийн хэрэгслүүдийн насжилт, элэгдэл зэргийг тооцон, 100 км гүйлтэд зарцуулах шатахуунд хэмжилт, туршилт явуулж, бодит нормыг тогтоолгүйгээр жишиг нормоос хэтрүүлэн шатахуун зарцуулж, бүртгэл тайланд тусгасан	Шатахуун зарцуулалтыг жолоочийн замын хуудсанд тухайн автомашины шатахуун зарцуулах норм болон зарцуулсан шатахууныг бичиж баталгаажуулан ажиллаж байна.	0
6	Зөвлөмж	-	Хөрөнгийг дахин үнэлээгүй	Бүрэн элэгдлээ нөхсөн боловч ашиглаж байгаа хөрөнгийг дахин үнэлэх буюу хөрөнгийн насжилтын хугацааг нэмэгдүүлэн цаашид ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж сумын ИТХ-аар актуулсан.	80
Нийт					68.3

Төрийн аудитын байгууллагаас хийсэн хөндлөнгийн хяналт шалгалтаар 2023 онд илэрсэн зөрчил дутагдлын хэрэгжилтийн биелэлт 68.3 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Алтанбулаг сумын ЗДТГ-ын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулж төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан байна. Харин өмч хөрөнгийн бүртгэл, хадгалалт хамгаалалт, хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүүгийн бүртгэл хөтлөлт анхан шатны баримтын бүрдүүлэлт хангаагүй дараах зөрчил, дутагдал илэрсэн. Үүнд:

Илрүүлэлт 1. "Нэг удаагийн тэтгэмж урамшуулал" -ын зардалд 392.4 мянган төгрөг батлагдсан байхад ЗДТГ-ын албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгийн төлбөр 3,820.8

мянган төгрөгийг “хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс төрөөс үзүүлэх дэмжлэг” зардлаас зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.2 дах “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт “Эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын 210901 кодыг, гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Илрүүлэлт 2. Шатахууныг Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан нормын дагуу тооцоогүйгээс 1,023.8 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 3.3, 3.6, 6.4 дахь заалтуудыг, Зам тээврийн хөгжлийн сайдын “Жишиг норм батлах тухай” 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм” нэгдүгээр хавсралттай нийцэхгүй байна

Илрүүлэлт 3

- Хүүхдийн баярын арга хэмжээнд 1,072.5 мянган төгрөг зарцуулснаас 123.18 мянган төгрөгийг хог хаягдал, орчны бохирдлын (82212) хөтөлбөрөөс, 320.0 мянган төгрөгийг хөтөлбөр төслийн дотоод урсгал (83112) хөтөлбөрөөс, 629.31 төгрөгийг үндсэн үйл ажиллагааны шатахууны зардлаас,
- Принтер засварын үнэ 910.0 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийн урсгал зардлаас нийт 1,982.5 мянган төгрөгийг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2: “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.2 дах “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт “Эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын 210901 кодыг тус тус зөрчсөн байна.

Илрүүлэлт 4. Монголын баялаг өв соёл ХХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавиагүй, 4,879.6 мянган төгрөгийн арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байхад санхүүжилтийг 100 хувь олгосон, авлага үүсгэж, бүртгэлд, тайланд урьдчилж гарсан зардлаар тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, “Монголын баялаг өв соёл” ХХК-тай байгуулсан гэрээний 3.2 дах заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Илрүүлэлт 5. Төсвийн хөрөнгөөр бий болсон 8,781.7 мянган төгрөгийн эд хөрөнгийг, 4,996.6 мянган төгрөгийн бараа материал, нийт 13,778.3 мянган төгрөгийн хөрөнгө, материалыг шууд зардлаар бүртгэсэн зөрчил илэрсэн

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 дахь “аж ахуйн бүх ажил, гүйлгээ” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 5.3.1-т заасан “Бараа материалын бүртгэл”-тай нийцэхгүй байна

Илрүүлэлт 6. Төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил гүйлгээний цахим төлбөрийн баримтыг бөөн дүнгээр бүртгэсэн 10,196.9 мянган төгрөгийн худалдан авалтыг бүртгэсэн байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжаар Алтанбулаг сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны санхүүгийн төсөв, гүйцэтгэл бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн, сумын ЗДТГ-ын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааны горимыг баримталж ажилласан байна гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Алтанбулаг сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт 35,681,9 мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс цаашид дахин давтан гаргахгүй байх санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн хугацаатай 4,844,6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 20,640,4 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлэхээр, төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил гүйлгээний цахим төлбөрийн баримтыг бөөн дүнгээр бүртгэхгүй байх зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил гүйлгээний цахим төлбөрийн баримтыг бөөн дүнгээр бүртгэсэн худалдан авалт хийхгүй байх зөвлөмжийг хүргүүллээ.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.


Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулж 25,485,0 мянган төгрөгийг төсвийн орлогын дансанд төвлөрүүлэхээр шийдвэрлэн улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн болно.

Шалгалтын тэмдэглэлд тусгагдсан үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллах, зөрчлийг арилгасан тухайгаа 2024 оны 09 дүгээр сарын 25-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр мэдэгдэхийг тус сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хариуцуулав.


БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ ДОТООД
АУДИТОР Г.ДОРЖДЭРЭМ



ТАНИЛЦСАН:

АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
У.ЯНЖИНДУЛАМ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ



Э.ЦЭНД-АЮУШ